



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/230

Чингис хот

Тусгаарлах вакуум хаалт хийхэд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Аймгийн онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 37 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар (Ковид-19)-ын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт өвчтэй иргэдийг тусгаарлах вакуум хаалт хийхэд зориулж хөрөнгө зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах 5,148,000 (таван сая нэг зуун дөчин найман мянган) төгрөгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011485

Аймгийн Засаг даргын 2021 оны  
05 дугаар сарын 10 өдрийн А/230  
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгжний үнэ	Нийт дүн
1	Вакум хаалтны үнэ	39 м <sup>2</sup>	132,000	5,148,000
	<b>Нийт дүн</b>			<b>5,148,000</b>